



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

МЭДЭГДЭЛ

Сүүлийн үед хувийн хэвшил рүү чиглэсэн олон нийтийн сүлжээ, мэдээллийн хэрэгслээр дайралт хийж буйтай холбоотой Монгол Улс дахь Америкийн Худалдааны Танхим (AmCham Mongolia) дараах мэдэгдлийг гаргаж байна.

Ажлын байр бий болгох, ард түмний аж амьдралыг дээшлүүлэх, инновацийг дэмжих, татварын орлогыг нэмэгдүүлэх болон эдийн засгийн тогтвортой хөгжлийг бүрдүүлэхэд амин чухал үүрэг гүйцэтгэж байдаг хувийн хэвшил болон чөлөөт зах зээлийг дэмжиж Улсын их хурлийн гишүүдийн зүгээс тэдний талд зогсох үйлээ үргэжлүүлэх нэн шаардлагатай үе болохыг тодотгоё.

Хувийн салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдүүд нь Монгол Улсын олон улс дахь байр суурийг тэлэх болон эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөрөнгө оруулалтын орчны болон хүний эрхийн тайланд тусаж, баталгаажсанчлан бизнесийн тогтвортой байдал, хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгохын тулд хууль тогтоогч болон хэрэгжүүлэгч байгууллагууд хувийн хэвшлийг оролцуулсан мөрдөн байцаах болон холбогдох бусад ажиллагаанд хуулийн хэмжээ хязгаарыг чандлан сахиж, бизнес эрхлэгч байгууллага, хувь хүний эрх, үйл ажиллагаа, нэр төрд хохирол учруулахаас сэргийлэх үүрэгтэй болохыг бид удаа дараа илэрхийлсээр ирсэн. Мөрдөн байцаах болон холбогдох бусад ажиллагаа нь хувь хүн, байгууллагын эрхийг хүндэтгэсэн, хэрэг хянан шалгах ажиллагааны зарчмыг баримталсан бөгөөд хөдлөшгүй, баталгаатай нотлох баримт дээр үндэслэсэн байх ёстай.

Мөрдөн байцаах ажиллагаа эхлүүлэх үндэслэл нотолгоо болж байгаа мэт ташаа ойлгогдохуйц сөрөг мэдээллийг олон нийтэд хүргэх буруу арга барил давамгайлах нь Монгол Улсад бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалт татах орчинд ихээхэн хохиролтой юм. Энэхүү арга барил нь бусдыг гэмт хэрэгт сэжиглэхээсээ өмнө холбогдох нотлох баримтаар баталгаажуулахыг шаардахын оронд гэм буруугүй тал өөрийн гэм буруугүй болохыг нотлохыг тулган шаҳдаг.

Энэ үед хэвлэл мэдээллийн байгууллага ялангуяа хувийн компани, түүний өмчлөгчтэй холбоотой аливаа мэдээллийг баримтад суурилсан, хариуцлагатай, мэргэжлийн ур чадвартай бэлдэж байх нь нэн чухал. Үнэн шударга, ил тод нийтийн хэлэлцүүлэг хийхэд үнэн бөгөөд бодитой сэтгүүл зүй зайлшгүй шаардлагатай тул цэгц шударга зарчмыг эрхэмлэхийг нийт хэвлэл мэдээллийн байгууллагуудад бидuri алж байна.